



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2020 оны 05 сарын 05 өдөр

Дугаар 40

Мандалговь

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4 дэх хэсэг, Сонгуулийн ерөнхий хорооны 2020 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 09 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Монгол Улсын Их Хурлын болон аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны ээлжит сонгуулийн, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны сонгуулийн хадгалах хугацаа нь дууссан саналын хуудсыг устгах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Ц.Мөнгөнцоож / аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга/
Гишүүд: Ж.Түмэндэлгэр / аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ахлах ажилтан
Ц.Цэнгэлмаа / аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ-ийн ахлах мэргэжилтэн/
Д.Сольхүү / аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны нягтлан бодогч /
Нарийн бичгийн дарга:
Ч.Оюунсайхан / Аймгийн Архивын тасгийн сан хөмрөгийн эрхлэгч

Хоёр Саналын хуудсыг холбогдох журмын дагуу устган, тэмдэглэл үйлдэж, тайланг Сонгуулийн Ерөнхий хороонд хүргүүлэхийг ажлыг хэсэг (Ц.Мөнгөнцоож)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.СҮХБААТАР



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2020 оны 05 сарын 05 өдөр

Дугаар 42

Мандалговь

Монгол Улсын цол хүртээх, одон,
медалиар шагнуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн 20.1.8 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Хөдөө аж ахуйн салбарт олон жил, үр бүтээл, идэвх зүтгэл гарган ажилласан Сайхан-Овоо сумын ахмад малчин Сүрэнхорын Цэгмидийг Монгол Улсын Төрийн дээд шагнал “Гавьяат малчин” цолоор шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжилсугай.

Хоёр. Шагналын материалыг холбогдох хууль, журам зааврын дагуу бүрдүүлж Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга (Ц.Мөнгөнцоож)-д үүрэг болгосугай

ДАРГА  С.СҮХБААТАР

